



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 21 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 58

Даланзадгад сум

“Эрүүл элэг” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 112, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Эрүүл элэг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж, арга хэмжээний зардлыг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

462210093

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 01-ний
өдрийн 58 дугаар тогтоолын хавсралт

“ЭРҮҮЛ ЭЛЭГ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий дахинд 2 тэрбум гаруй хүн вируст гепатитийн архаг халдвартай амьдарч байгаа бөгөөд жил бүр 1.4 сая хүн уг өвчнөөс үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдрын улмаас нас барж байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр дэлхий дахинд 110 сая гаруй хүн вируст С гепатитийн халдварт өртөж, тэдгээрээс 80 сая гаруй хүн гепатит С вирусийн идэвхтэй халдвартай, 240 сая хүн гепатит В вирусийн архаг халдвартай амьдарч байна. Халдвар авсан гурван хүн тутмын нэгд элэгний цирроз, элэгний өмөнгөөр өвчилж байна.

Монгол Улсын насанд хүрсэн хүн амын дунд гепатит С вирусийн архаг халдвар 11-16%, гепатит В вирусийн халдвар 10.6-11.1%-ийн тархалттай байна. Гепатит В, Д вирусийн халдвар өргөн тархсан, гепатит В вирус тээгч хүмүүсийн 60-аас дээш хувь нь оношлогдож байна. Манай орон 100 000 хүн амд ноогдох элэгний өмөнгийн нас баралтаар дэлхийд нэгдүгээр байрыг эзэлж, энэхүү үзүүлэлт нь дэлхийн дунджаас даруй найм дахин өндөр байна.

Өмнөговь аймаг нь 2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн ам 69902, хөдөлгөөнт хүн ам 70,000 гаруй болсон бөгөөд суурин хүн амын 51.1% нь эрэгтэйчүүд, 48.8 % нь эмэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг /10000 хүн амд 3238.8/ энэ нь 2019 онд 3179.0-р 2-рт орж байсан бол 2020 онд 59.8 промилээр нэмэгдэж тэргүүлэх шалтгаан болж байна.

Аймгийн хэмжээнд элэгний хорт хавдрын өвчлөл нийт хавдрын өвчлөлийг тэргүүлж байгаа бөгөөд жилд дунджаар 35 орчим хүн шинээр хяналтанд орж, 71.4 хувь нь сүүлийн шатандаа оношлогдож байна. Элэгний А, В, С, Д вирусийн халдвар нь элэгний өмөнгөөр өвчлөх шалтгаан болж байна. Хүн амын дунд С вируст гепатитын халдвар 15.6, В вируст гепатитын халдвар 11.8, дельта вирусийн халдвар 4.8 хувийн тархалттай байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2016-2020 онд “Элэг бүтэн-Өмнөговьчууд” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт хүн амын 83% хувьд нь гепатит вирусийн халдварын эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Элэгний С вирусийн халдвартай 2649 иргэн, В вирусийн халдвартай 2509 иргэнийг шинээр илрүүлж эмчилгээнд 38.9%-ийг хамруулсан байна. Хөтөлбөр хэрэгжсэнээр элэгний хорт хавдрын нас баралт жилд дунджаар 10 тохиолдлоор буурсан эерэг үр дүнтэй гарсан. Гепатитийн С, В вирусийн эсрэг эмэн эмчилгээг өргөжүүлж, эмч мэргэжилтнүүдийн чадавхжуулах, орчин үеийн арга, техникээр орон нутагт вирусийн ачаалал тоолох шинжилгээг хийж эхэлсэн нь гепатитийн вирусийн халдварын тусламж, үйлчилгээг улсын түвшинд хүргэхэд чухал алхам болсон.

Гэсэн хэдий ч сүүлийн таван жилд аймгийн хэмжээнд элэгний хорт хавдар хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болсоор байна. Нийт нас баралтын 37.5%

хувийг эзэлж байна. Манай оронд 100 000 хүн амд ноогдох элэгний өмөнгийн нас баралтаар дэлхийд нэгдүгээр байрыг эзэлж, энэхүү үзүүлэлт нь дэлхийн дунджаас даруй найм дахин өндөр байна.

Хепатитийн вирусийн халдварын талаарх хүн амын мэдлэгийг дээшлүүлэх, зан үйл, хандлагыг өөрчлөх, өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ халдвараас хамгаалах мэдлэг, дадалтай болгох, уг вирусийн архаг халдвартай байгаа хүнийг илрүүлэн эмчилгээнд хамруулах, элэгний хатуурал, хорт хавдрыг эрт үед нь оношлох, эмчлэх, хепатитийн вирусийн халдвар дамжих замыг таслах чиглэлээр цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлага хэрэгцээ тулгарч байна.

Иймд хүн амын өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа элэгний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага эрт илрүүлэх үзлэг, шинжилгээг хангалттай зохион байгуулж байгаа боловч, вирусийн идэвхжил тодорхойлох, шинжилгээнд илгээх, эмчлэн эрүүлжүүлэх, эмчилгээний нэрийн хяналтыг сайжруулах, дархлаажуулалтыг эрчимжүүлэх, дархлал тогтцыг тогтоох, иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, ард иргэдэд чирэгдэлгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх цогц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

2.1.1. Хүн амын дунд хепатитийн вирусийн халдварыг эрт илрүүлж, үзлэг оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд бүрэн хамруулж, хепатитийн вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулна.

2.2. Хөтөлбөрийн зорилт

1 дүгээр зорилт: Хүн амыг хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг судлах судалгаа шинжилгээ, мэдээлэл сургалт сурталчилгаа, дархлаажуулалтын арга хэмжээг өргөжүүлэх, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх замаар халдварын тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.

2 дугаар зорилт: Хепатит вирусийн халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эмчилгээнд хамрагдалтын хувийг эрс нэмэгдүүлнэ.

3 дугаар зорилт: Элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

2.3.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.1.1. Нийт хүн ам болон эрхэлсэн ажил, эрүүл мэнд, амьдралын хэв маяг, зан үйлээс хамааран хепатитийн вирусийн халдварт өртөх эрсдэл бүхий зорилтот бүлгийг хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйл, амьдралын дадал, хэвшилд сургах чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааны аян зохион байгуулах;

3.1.2. “Ундны ус хоол боловсруулах замын эрхтэн тогтолцооны өвчлөлийг үүсгэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг судлах судалгаа шинжилгээний арга хэмжээг зохион байгуулах;

3.1.3. Өсвөр үе, оюутан, залуучуудаас үе тэнгийн сургагч багш, эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн бэлтгэж, тэдгээрээр дамжуулан хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

3.1.4. Гэрийн нөхцөлд тарилга хийлгэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллагаар арьс, салст гэмтээх ажилбар хийлгэх зэрэг хепатитийн вирусийн халдвар дамжих эрсдэлд өртөхөөс өөрийгөө хамгаалах талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр иргэдэд зөвлөгөө өгч хэвшүүлэх;

3.1.5. Хепатитийн В, С вирусийн халдварын тохиолдол шинээр бүртгэгдэх бүрт халдвар дамжих замыг тодорхойлох тандалт судалгаа хийх;

3.1.6. Хумс засах, шивээс хийх, чих цоолох зэрэг гоо сайхны үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх халдваргүйжүүлэлт, ариутгалын журам, зааврыг боловсруулж мөрдүүлэх;

3.1.7. Хепатитийн В вирусийн халдварын эсрэг дархлал тогтоцын түвшингийн судалгааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, дархлааны түвшин нь хангалтгүй бүлгийн хүн амыг нэмэлт дархлаажуулалтад хамруулах;

3.1.8. Эрхэлсэн ажил, амьдралын хэв маяг, зан үйл, эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хепатитийн В вирусийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй бүлгийн насанд хүрэгчдийг хепатитийн В вирусийн эсрэг сэргийлэх тарилгаар дархлаажуулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах, хамралтад хяналт тавих;

3.1.9. Насанд хүрэгчдийг өөрийн хүсэлтээр болон эрхэлж байгаа ажил, үйлчилгээний онцлогоос шалтгаалан сайн дурын дархлаажуулалтад хамруулах журмыг шинэчлэн боловсруулж, сайн дурын дархлаажуулалтаар хийх сэргийлэх тарилгын тоог нэмэгдүүлэх;

3.1.10. Хепатитийн вирусийн халдварын тохиолдлын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний хяналт хийх цахим программ ашиглалтыг нэмэгдүүлэх, цахимд суурилсан тандалт, хяналтын тогтолцоог эрчимжүүлэх;

3.1.11. Хепатит вирусийн халдвартай иргэдэд тусламж үйлчилгээ үйлүүлэх эмнэлгийн эмч ажлчдад эмчилгээ, оношилгооны удирдамж баримтлан тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх чиглэлээр үе шаттай сургалт, дэмжлэг, хяналт хийх;

3.1.12. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүр цирроз, хорт хавдартай иргэдэд үзүүлэх гэрийн хяналт, тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр цогц ажлыг зохион байгуулах.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.2.1. Хепатитийн вирусийн халдварын илрүүлгийг элэгний хатуурал, хорт хавдрын эрт илрүүлэгтэй хамтатган үе шаттайгаар зохион байгуулах;

3.2.2 Эрхэлсэн ажил, эрүүл мэнд, амьдралын хэв маяг, зан үйлээс хамааран хепатитийн вирусийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй бүлгийн хүн амыг хепатитийн В, С вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд тогтмол, давтамжтай хамруулах;

3.2.3. Хепатитийн В вирусийн халдвартай эхээс хүүхдэд халдвар дамжихаас сэргийлэх зорилгоор төрсний дараа 24 цагийн дотор нярайд хепатитийн В вирусийн эсрэг вакциныг иммуноглобулин (HB-Ig)-аар хангахад дэмжлэг үзүүлж ажиллах;

3.2.4. Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх зорилгоор зорилтот бүлгийн хүн амыг үзлэг, шинжилгээнд тогтмол, давтамжтай хамруулах;

3.2.5. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лабораторид хепатитийн вирусийн идэвхжил тоолох шинжилгээ хийх, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих боломж нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.6. Хепатитийн вирусийн халдвар, элэгний хорт хавдрыг илрүүлэх, онош баталгаажуулахад шаардлагатай лабораторийн орчин үеийн дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, тоног төхөөрөмжөөр хангах;

3.2.7. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг хепатитийн вирусийн халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт шаардагдах тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодисоор үе шаттай хангах;

3.2.8. Хепатитийн вирусийн халдвар, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын эмчилгээнд орчин үеийн дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх, эмч, мэргэжилтнийг чадавхжуулах;

3.2.9. Хепатитийн вирусийн халдвартай, вирусийн тархалт ихтэй, эрсдэл өндөртэй хүн амын бүлгээс эхлэн вирусийн эсрэг эмчилгээнд хамруулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.3.1. Элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;

3.3.2 Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хавдрын кабинетийг хөгжүүлж орон нутаг дахь хавдрын эмчилгээ, оношилгоо, шинжилгээний чадавхийг бэхжүүлэх;

3.3.3 Орон нутагт хавдрын өвчтэй хүмүүст үзүүлэх хөнгөвчлөх эмчилгээ, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төвийг байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэн эмчлэх нөхцөл бүрдсэнээр хорт хавдрын шалтгаант нас баралт буурч, хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.

4.1.2. Хүн амын бүлэг бүрт тохирсон, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулагдаж, хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд хувь хүний оролцоо нэмэгдэнэ.

4.1.3. Хепатитийн вирусийн халдвар дамжих замыг таслан зогсоосноор өртөж болзошгүй хүн амыг халдвараас сэргийлэх боломж бүрдэнэ.

4.1.4. Дархлаажуулалт, эрт илрүүлгийн хамралт нэмэгдсэнээр өвчлөл эндэгдлийн түвшин буурна.

4.1.5. Өвчнийг эрт илрүүлснээр эмчилгээг цаг алдалгүй хийлгэн хүндрэлээс сэргийлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулж, чанартай амьдралын хугацааг уртасгана.

4.1.6. Эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, оношилгоо, шинжилгээнд техник, технологи, эм, урвалжийн шинэчлэл хийгдэж, хепатитийн вирусийн шинжилгээ, оношилгоог, эмчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

Тав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үр нөлөөний болон үр дүнгийн дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2020 оны эрүүл мэндийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглана:

5.2. Эрүүл мэндийн газрын статистик мэдээллийг үндэслэн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тооцно.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин			
		2020	2021	2022	2023	2024
1.	Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 18-аас дээш насны иргэдийн хувь	83% /17660/	84%	86%	87%	88%
2.	Тухайн жилд эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын дундах хепатит В вирусийн өвчлөлийн түвшин	2.3% /455/	2.0%	1.8%	1.6%	1.4%
3.	Тухайн жилд эрт илрүүлэгт хамрагдсан хепатит С вирусийн өвчлөлийн түвшин	2,04% /390/	1.9%	1.6%	1.3%	1.1%

4.	Элэгний В, С вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдвал зохих иргэдээс хамрагдсан хүний хувь	50% /215 хүн/	57.5%	65%	72.5%	80%
5.	Хепатитийн В вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдээс вирусийн идэвхжил нь дарангуйлагдсан өвчтөний эзлэх хувь	71,8% /275 хүн/	75,7%	78.6%	83.5%	87.4%
6.	Хепатитийн С вирусийн эсрэг эмчилгээний горимыг бүрэн дуусгасан өвчтөнүүдээс бүрэн эмчлэгдсэн иргэдийн эзлэх хувь	91,5% /496 хүн/	93.1%	94.7%	94.4%	95.7%
7.	В хепатитын сайн дурын дархлаажуулалтад хамрагдсан 18-с дээш насны иргэдийн тоо	13.9% /2393/	15.9%	17.9%	19.9%	21.9%
8.	Элэгний өвчлөлийн тухайн жилийн шинэ тохиолдол /10,000 хүн амд/	0.1	0.1	0.1	0.1	0.1
9.	Элэгний эмгэгийн эндэгдэл, тохиолдол /10,000 хүн амд/	48	45	42	38	33
10.	Нийгмийн эрүүл мэндийн сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	13.5%	33.5%	53.5%	73.5%	83.5%
11.	Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүн амд)	2.9	2.8	2.7	2.6	2.5
12.	Хепатит вирусийн эсрэг эм бичих эрхийг баталгаажуулсан эмчийн тоо	3	7	14	18	18

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

6.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө

6.1.3. Олон улсын байгууллага, гадаадын улс орны төсөл, зээл, тусламж

6.1.4. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, хандив

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна.

7.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс 1 жил тутамд хөтөлбөрийн явцын хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн

Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна. Мөн хагас жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн Нийгмийн бодлого, Хууль эрх зүйн хороонд танилцуулна.

Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар хариуцна.

8.2. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нар хариуцан зохион байгуулна.

----oOo----